

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас зохион байгуулан явуулдаг байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах, мэдээ мэдээллээ ил тод шуурхай солилцох ажлын хүрээнд сар бүрийн ажлын эхний өдөр “УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАГ”-ыг 2022 оын 6 сарын 6-ны өдөр хуралдаж сумын нийт албан байгууллагуудын дарга эрхлэгч нартай уулзан мэдээлэл солилцон одоогийн цаг үеийн байдал болоод ирэх сард хийхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар санал солилцон ажилласан.

Төрийн одон медаль авсан ээжүүдэд хүндэтгэл үзүүлэн ажилласан. Мөн Хүүхдийн баярын өдөр “Жаргалтай хүүхэд нас” арга хэмжээг санаачлан зохион байгуулсан.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, Сумдын ИТХ-ын хамтын ажиллагааг сайжруулах туршлага солилцох зорилгоор уламжлал болгон зохион байгуулагдсан арга хэмжээ 2022 оны 6 дугаарсарын 16-17 ны өдрүүдэд болсон. Уг арга хэмжээнд 13 сумын ИТХ-ын 150 гаруй албан хаагчид болон төлөөлөгчид оролцсон.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Хяналт шинжилгээ үнэлгээний цахим системд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг 6 дугаар сарын 20 ны дотор шивж орууллаа. Сумын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт, аймгийн ИТХ-ын тогтоолын биелэлт, аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтүүдийг тус тус 07 дугаар сарын 05 ний дотор тайлагнан ажиллахаар төлөвлөж байна.

Засаг даргын захирамжаар байгуулагдсан Дотоодын хшү ний ажлын хэсэг байгууллага, мэргэжилтнүүдийн эхний хагас жилийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу 5 дугаар сарын 17-25 ны өдрүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллалаа. Засаг даргын зөвлөлд 2022 оны 6 дугаар сарын 28 ны өдөр танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ЗДТГ дээр ажлын байрны цаг ашиглалтын зураг авалтын хуваарийг Тамгийн газрын даргаар батлуулан 7 хоног бүр албан хаагчид ээлжлэн ажлын байрны зураг авалт хийж ажиллаж байна.

Газар дэлхий ХХК нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж буйтай холбоотойгоор холбогдох 2 мэргэжилтэн 6 дугаар сарын 22-23 ны өдрүүдэд ажиллаж шаардагдах статистак тоон мэдээллүүдийг авч ажиллав.

Засгийн газрын 194, 192 дугаар тогтоол гарсантай холбогдуулан төрийн захиргааны-5, төрийн үйлчилгээний 6 албан хаагчдын цалинг шинэчлэн хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд оруулж ажиллалаа.

Тулгар төрийн 2231, Их Монгол улс байгуулагдсаны 816, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан "Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль"-аар шагнах 30 иргэдийн мэдээллийг аймгийн төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлж ажиллав.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан бичил төсөл хөтөлбөрт "Хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт төслийг 6 дугаар сарын 24 ны өдөр хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлж ажиллав.

06 дүгээр сард: Ирсэн бичиг–10, Явсан бичиг – 20, Хариутай бичиг – 3
Хугацаандаа явсан бичиг – 3, Хугацаа болоогүй бичиг – 0, Хугацаа хэтэрсэн бичиг – 0 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу 10 жилд 1 удаа хийгддэг хөдөө аж ахуйн тооллого 2022.06.06-14 хооронд хийгдэж дууслаа. Ажлын хэсэг байгуулах сумын засаг даргын 2022.05.16 өдрийн А/56 тоот захирамж гарч тооллогонд 2 тоологч, 1 хянагч ажиллалаа. Тооллогонд газар тариалан эрхэлдэг 13өрх, 4 байгууллага, мал аж ахуй эрхэлдэг 132 өрх, 2 байгууллага нийт 151 нэгж тооллогын хүрээнд хамрагдаж тооллогыг хугацаанд нь дуусгалаа. Тооллоготой холбоотой 825200 төгрөгийн зардал гарсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого хийгдэж дууслаа. Хөрөнгийг нэг бүрчлэн холбогдох баримт материалын хамт burgtel.gov.mn бүрэн оруулж илгээсэн.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар зохион байгуулагддаг сургалтад нийт 18 албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

Төрийн албаны сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан хүний нөөц хариуцсан албан хаагчдыг чадвахижуулах сургалтад улаанбаатар хотод төрийн албаны төв зөвлөл дээр 06 дугаар сарын 16-17 ны өдрүүдэд 2 өдөр хүний нөөц хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.

ОНХС-н мэдээллийг Удирдлага мэдээллийн системд шивж оруулах үүрэг бүхий БЗД болон ОНХС хариуцсан мэргэжилтэн нарт зориулсан цахим сургалт 23-ны 09-11 цагийн хооронд явагдаж холбогдох албан хаагчид хамрагдлаа.

Монгол улсын Засгийн газраас батлагдсан шинэ журмуудын нэмэлт өөрчлөлт болон түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлууд, аймгийн бодлого шийдвэрүүдийн гүйцэтгэл, үр дүн, биелэлтийг цахим системд хэрхэн тайлагнах аргачлалыг танилцуулж, зөвлөмж арга зүйгээр ханган бодлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор 6 дугаар сарын 20-21 ны өдрүүдэд Сүхбаатар суманд зохион байгуулагдсан бүсийн сургалтад 6 албан хаагч хамрагдлаа.

УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Жендэрийн тухай хуулиудаар тус тус сонсгол мэдээллийн цагаар мэдээлэл өгч ажиллалаа.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтад нийт 52 албан хаагчийг хамруулж ажиллав.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ерөнхий боловсролын сургууль: 5-р сарын 27-6-р сарын 10-ны өдрүүдэд анги дэвших болон улсын шалгалтуудыг амжилттай зохион байгуулсан.

Италийн "Asia Mongolia" ТББ-ын төлөөлөл ирж 2022 оны 9-р сараас мэдээлэл технологийн чиглэлээр хэрэгжих төслийн талаар нөхцөл байдлын судалгаа хийж, санал бодлоо солилцлоо.

Дотуур байрын сурагчдын болон үдийн цайны сурагчдын хоол хүнсэнд хэрэглэх зорилгоор сургуулийн гадна талбайд нарийн ногоо, төмс хүний ногоо тариалсан.

9-р анги төгсөгчдийн гэрчилгээ гардуулах ёслолыг амжилттай зохион байгуулж 9 жил дараалан “А” үнэлгээтэй суралцсан төгсөгчдөд сургуулийн Тэргүүний сурагч тэмдэгийг гардуулсан.

Тус сургуулийн номын сангийн 2018-2021 оны I –IX ангийн сурах бичгийн ашиглалтанд сургуулийн захирлын тушаалаар томилогдсон тооллогын комисс тооллого хийж анги тус бүрээр актлах болон ашиглах номыг тоолж актлах номын жагсаалтыг гарган ажиллалаа.

Соёлын чиглэлээр: Соёлын төвд бусад байгууллагын хамтарсан үйл ажиллагаа 7 удаа зохион байгуулагдсан байна.

Номын сан нь өдөр тутмынхаа үйл ажиллагааг хэвийн явуулж байна. 06 сард танхимаар 6 иргэнд, гэрээр ном олгох үйлчилгээ 3, шинээр 1 иргэнд карт нээж үйлчиллээ. Номын сангийн соёл олон нийтийн чиглэлээр зохион байгуулсан ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн нийтийн номын сангаас хамтран зохион байгуулсан “Уран үгс эгшиг дууны яруу үдэш” нэг өдрийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр аймгийн нийтийн номын сангаас номын үзэсгэлэн гаргаж сургуулийн дотуур байрны сурагчдад Үлгэрийн багц ном бэлэглэлээ. Орой нь 19 цагаас 5000₮ такстай үдшийн цэнгүүнийг зохион байгуулж орсон орлогыг Сүхбаатар аймгийн 80 жилийн ой арга хэмжээнд хандив болгон өргөж ажилласан.

Түүх соёлын дурсгалын зүйл шинээр нээн илрүүлэх , ажлыг иргэн Х.Батэрдэнэтэй хамтран илрүүллээ. Сумын төвөөс урагш 8 кмт байгалийн өөрийн өвөрмөц тогтож, гайхамшигийг харуулсан зүрхэн хэлбэртэй хадыг шинээр бүртгэн баримтжуулж ажиллаа. Мөн соёлын биет болон биет бус өвд шинээр 8 иргэнийг Халх богино дуу, мал маллах арга ухаанд бүртгэлээ.

Дуу хөгжмийн багш Б.Батбаатар нь үндсэн ажил үүргийнхээ дагуу бага ангийн 6 сурагч, дунд ангиас 6 сурагч нийт 12 хүүхдийн бүрэлдэхүүнтэй үкүллэ хөгжмийн дугуйланг хичээллүүлж байна.

Байгаль орчны чиглэлээр: 2000 ширхэг хайлаас модны суулгац авчирч албан газар аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд хувиарлан өгч тарих ажлыг зохион байгуулав.

Ө. Балжидийг ХААИС-ийн ойн инженерийн 2,5 жилийн баклаварийн сургалтанд хамруулах хүсэлтийг аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүллээ.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх 20,2 тун вакцин татан авч 13962 үхэр 4910 тугал нийт 18872 мал хамрагдаж 18872 тун вакин зарцуулж 1328 тунг хэвийн хорогдолд устгалаа.

Гарааны праймер ХХК , мал эмнэлгийн дундын хоршоо-той хамтран мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн,хувийн хэвшлийн малын эмч нарын сургалт мэдээлэл өгч, мөн Мал амьтны гоц халдварт өвчний эрт илрүүлэг хариу арга хэмжээ болон оролцоот эпидемиологийн тандалтын сургалтыг 13 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдэд зохион байгуулж танхимаар 36 онлайнаар 16 нийт 52 хүн хамрагдсан.

Сүхбаатар аймгийн онцгой комиссын 01/09 үхрийн арьс товруутах өвчний эмнэлзүйн үзлэгийг 4 багийн нийт үхэрт хувийн хэвшлийн малын эмч , тасгийн эмч нар хамтран 28 хоногийн мөчлөгтэй 7 хоногийн зайтай 4 удаагийн давтамжтай хийх ажлын төлөвлөгөөг гаргаж зураглал, бензин тосны судалгааг гаргаж өгсөн .

Сумын Засаг даргын албан тоотыг 4 багийн засаг дарга нарт хүргүүлж үхрийн арьс товруутах өвчний тарилгад хамрагдаагүй өрхийн судалгааг нэн яаралтай гаргаж өгөх судалгааг хүргүүлсэн.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
Д.ДАЙРИЙМАА

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН